



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/378

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 3.5.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос улсад жил бүр зохион байгуулагддаг залуус солилцоо хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд орон нутгаа төлөөлөн оролцох Ч.Бат-Өлзийгийн замын зардалд 1620000 (нэг сая зургаан зуун хорин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 1620000 (нэг сая зургаан зуун хорин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100614